

## УРАН ЗОХИОЛ ДАХЬ “ЧОНЫН ДҮР”

(Д.Намдагийн “Хөгшин чоно ульсан нь” ба Зян руны “Чонон сүлд”)

Т.Саран (T.Saran)

(МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн, Нийгэм хүмүүнлэгийн сургуулийн  
Утга зохиол урлаг судлалын тэнхимийн докторант)

Аль ч улс үндэстний аман зохиол, уран зохиолд амьтны дүрүүд байдаг ба энэ нь хэвшин тогтворжсон, биеэ даасан, тусгай тусгай хэв шинийн илэрхийлэл болдог. Өөрөөр хэлбэл аман зохиол, уран зохиол дахь амьтны дүрүүдийнх ихэнх нь хэвшсэн хэв шинжтэй, үүнийгээ дагаад тогтсон үлгэр, өгүүлэмжтэй болсон байдаг. Жишээ нь:

- **Үнэгний дүр:** гэхэд хулжин хуйхар, заль мэхтэй хүмүүсийн төлөөлөл дүр болдог бол,
- **Хонь:** нь номхон шударга, ноомой хүмүүсийн төлөөлөл дүр болж байна.
- **Туулай:** нь цэцэн сэргэлэн, оюун ухаантай хүмүүсийн төлөөлөл дүр болдог.
- **Баавгай:**-н дүр салан задгай, хөдөлгөөн удаантай, болхи бүдүүлэг хүний төлөөлөл дүр байна.

Үүний нэгэн адил бидэнтэй ойрхон байдаг аман зохиол, уран зохиолын нэгэн амьтны дүр бол **ЧОНЫН ДҮР**. Монгол утга зохиол аман зохиолд “Чонын дүр” нэн элбэг. Ингэхдээ ихэвчлэн онгироо дээрэнгүй, ховдог шунахай маягийн хүний төлөөлөл дүр болдог. Тэгвэл бид энэ удаа Д.Намдагийн “Хөгшин чоно ульсан нь” тууж ба Зян руны “Чонон сүлд” роман дахь чонын дүрийг харьцуулан үзэж, аман зохиолд үзүүлдэг чонын төлөөлөл дүртэй адил эсэх байгаа тухай, эсвэл өөр ондоо байна уу гэдгийг тодруулах үүднээс зарим нэг өгүүлэмжид тулгуурлан авч үзсэн болно.

- **Зян рун “Чонон сүлд”** романдаа тал нутгийн малчид болоод чонын амьдралаар төлөөлүүлсэн хятад орны байгаль ахуй хэрхэн эвдэрч сүйтгэгдэж байгааг, зохиолын баатар Чен Жэний бодол эргэцүүлээр дамжуулан, хүн төрөлхтөн байгаль ертөнцтэйгөө эе зохицолтой харьцах, байгаль ба нийгмийн тэнцвэрийг батлан хамгаалах хэрэгтэй гэдгийг зохиолдоо тусган үзүүлжээ.
- Тэгвэл **Д.Намдаг гуай “Хөгшин чоно ульсан нь”** тууждаа “хариутай бол бариутгай” гэдэг шиг, байгаль, нийгмийн жам хуулийг дагахгүй бол байгалиас хүн төрөлхтөн хариу нэхэх зүйл байгаа гэснийг, хэдэн чонын алалдаанаар үзүүлээд, хүмүүст байгалийн зохицлыг хэрхэн баталж явахыг санаачлан харуулсан байна.
- Зян руны “Чонон сүлд” роман дахь чоно нь эрэлхэг хүчтэй оюун ухаан сайтай, тэсвэр тэвцээртэй мөртөө эрх чөлөөнийхөө төлөө амь биеэ хайхралгүй тэмцдэг нэн чухал нь байгалийн эшин гинжийн холбоонд чухал хувь нэмэртэй байдаг гэх талаас нь илүү үнэлж үзүүлсэн байх бол
- Д.Намдагийн “Хөгшин чоно ульсан нь” гэх туужид хүн байгалийн эе зохилдлого, хүн байгалтай эе зүйтэй харьцан байх ёстой гэдгийг батлан харуулсан. Үүгээр роман, тууж хоёр нь нийтлэг, адилхан шинжтэй.

Энэ бүхнийг тодруулах үүднээс,

1. Хоёр зохиол дахь чоно идэш, олзоо олзолж байгаа өгүүлэмж
2. Хоёр зохиол гарч буй чонын тухай бодол өгүүлэмж
3. Хоёр зохиол дахь чонын зугтаж байгаа байдлын өгүүлэмжийг ажиглан судалсан болно.